

С. Эрдэнэ
“Өвгөн шувуу”
ӨГҮҮЛЛЭГ



С.Эрдэнэ 1929.07.7 онд Хэнтий
аймгийн Биндэр сумын
нутаг

Офицерийн сургууль, МУИС-

Эх бүрдийн бүрдийн домог
,Жаргал даахгүйн зовлон
кино ,Амьдралын тойрог
,Холбоо 3 тууж,Хулан бид
2,Хулан Цамба 2 ,Хулан 30
жилийн дараа ,Наран
тогоруу ,Малын хөлийн тоос
зэрэг олон шилдэг бүтээл

1965 онд төрийн шагнал ,1976
онд СГЗ, 1994 онд Ардын
уран уран зохиолч


2000 онд үүрдийн их амар
амгаланг олсон



Зохиолын өгүүлэгэхүүн, сэдэв, асуудал, гол санааг тодорхойлоорой.

ТУЙЛ –

Үйл явдлын зөрчил оргилдоо хүрч хүрч хурцдах- Жав гуайг ширдэг дээр дамнан гаргаж, тэр найз өвгөчүүлдээ хуйв, хөөргөө найзууддаа өгч буй тухай



Хам сэдэв гэж юу вэ?

Зохиолын дүрийг тодруулж буй орон, цаг үе, нийгэм, соёлын нөлөөлөл, үзэл бодол зэрэг зохиолын хамгийн их мэдээлэлтэй хэсгийг хэлнэ.

- Түүхийн хам сэдэв
- Нийгмийн хам сэдэв
- Соёлын хам сэдэв
- Шашны хам сэдэв
- Улс төр, эдийн засгийн хам сэдэв

Хам сэдэв

Бид чинь ингээд л уван цуван хойд энгэртээ гарах улс шүү дээ. Жам юм хойно.

Жам ёсны тухай



Хөөрөг, гаанс – Хэдийгээр эд хураадаг ч гэмгүй явсан нөхдөдөө нөхөрлөлийн тэмдэг болгож өгдөг ёс

Үхлийг жам ёсны үзэгдэл тул гашуудаж, ганьхарч хүлээж авдаггүй, үхэж байгаа хүнийхээ ч тэр, үлдэж байгаа нэгнийхээ ч тэр сэтгэлийг амар амгалан байлгах, түүгээр ч зогсохгүй

Монгол ахуй
Монгол соёл
Монгол эх орон

Орчин \ setting\ гэж юу вэ?

Зохиолын үйл явдал болж байгаа орон газар, үйл явдал болж байгаа цаг хугацааг зохиолын орчин гэнэ. Зохиолын орчин нь дүрийн зан төрхийг дэмжих, сэдвийг дэмжих, гол санааг дэмжих зэргээр холбоо хамаарал үүсгэнэ.

Орчинг тодорхойлохдоо:

- ❑ Орон, цагийг заасан үгийг түүнэ.
- ❑ Зохиолд дүрсдэгдсэн орон, цаг бүрд гол дүрүүд ямар үйлдэл хийснийг тодорхойлно.
- ❑ Энэ задлалаас зохиолын сэдэв, гол санаа, дүрийн зан төрхийн ялгараа харагдана.

Орон- Хөдөө- гэрт (монгол ахуй, соёл, заншил- сэдэв)

Цаг хугацаа: Зун (Дүрийн шинж) (гунигтай хэдий ч уужуу, хөгжилтэй, өгөөмөр, нөхөрлөлөө дээдэлдэг дэлгэр зан, харамсахааргүй гэр төртэй амьдрал,)

Зохиолын нөхцөл байдал \situation\

Зохиолд дүрслэгдэж байгаа орон, цагийн доторх хүрээлэн буй орчин, юмсын дүрслэлийг хэлнэ.

Нөхцөл байдлыг тодорхойлохдоо:

- ❑ Тухайн орчинд \орон, цаг\ ямар хүрээлэн буй орчныг дүрсэлснийг тогтоох
- ❑ Тухайн нөхцөл байдал нь дүрийн зан төрхийг харуулахад яаж нөлөөлж байгааг тайлбарлах

Үхлийн өмнөх сэргэлт (хууралт): Явж байгаа, үдэж байгаа нэгэндээ харамсах зүйлгүй, өгье ярья, захья гэснээ гүйцээж, харамсах юмгүй, хоргодох зүйлгүй одохыг чухалчилдаг монголчуудын сэтгэлгээ, үхлийг үзэх үзэл (сэдэв)

Зохиолын уур амьсгал \atmosphere\

Зохиолд дүрслэгдсэн дүрүүдийн хоорондын харилцаа, сэтгэгдэл, мэдрэмж, сэтгэл хөдлөлийг зохиолын үг хэлээр дамжуулан дүрсэлснийг хэлнэ.

Уур амьсгалыг тодорхойлохдоо:

- Дүрийн тухайн хүн, юмсын талаарх сэтгэгдэл, мэдрэмж, сэтгэл хөдлөлийг дүрсэлсэн үг хэллэгийг ажиглах
- Зохиолын дүрүүдийн харилцан, яриа, бодлыг ажиглах
- Ямар орчин, нөхцөлд дүр хоорондын харилцаа яаж өөрчлөгдөж байгааг тэмдэглэх
- Эндээс уншигч та ямар өнгө аясыг мэдэрч, юуг ухаарч байгааг тайлбарлана.

Жав өвгөчүүлийг хөгжилтэй, наргиатай угтаж авсан нь уг зохиолын дүрүүд залуу цагийн хөгжилтэй, адал явдалтай үйлдлүүдээ дурсан ярилцаж, инээд хөөр болж байгаа, нөхөрлөлийн бэлгэ тэмдэг (Амгалан, тайван, уужуу)

Зохиолын уран дүрслэл ба далд утга

Сэдэв- Амьдралын жам ёсны (үхэл) тухай (цаг цагаараа байдаггүй тухай)

Тэмдэг нэрээр дүрсэлсэн нь

Зовхи нь хөх няц

Гэрэлгүй нүд

Ихэд хүндэрсэн толгой

Хянган хамар

Горойж байдаг дотор

Зүрх нь удаан боловч лүг лүг

Хүрэн торгон дээл

Шар гуулин медаль

Өндөр дэр

Сийлбэр нь балартлаа элэгдэж мөлийсөн хөөрөг

Хүдэр хар өвгөн

Боргоцой Дорлиг

Шумуул Жамц

Гонгиносон нарийн дуутай өвгөн

Алтан цаг зүүсэн, сүүдэр шил зүүчихсэн

дэгжин шовгор өвгөн

Хөө тортог болсон сөөнгө дуутай

морин хуур

Эршүүд баргил хоолой

Уран дүрслэлээр (Хэлцээр)

Шанааны яс нь арьсаа цоо

татах вий гэмээр ёрдойх

Яс арьс болсон гар

Нүд халтирах

Газар хонхойтол бууж мордож явах

Хуучин бууны хугархай

Ганган хүнд гархи нэмэр

Сэтгэлээ барих

1. Нарыг тооноор, газрыг үүдээр харах
2. Нүд аних
3. Бөх голтой
4. Утсан чинээ улаан амь тасарч өгөхгүй
5. Хадан гэртээ харих
6. Долоон голтой
7. Өвчин нь газар авах
8. Утсан чинээ улаан гол цохилох
9. Голтой байх
10. Хүний тооноос хасах
11. Бие үхэхээс ухаан үхэхээс айх
12. Амьсгаагаа хураах
13. Цаг тулах
14. Амин дээрээ байлгах
15. Үхэлд тулах
16. Насан хэвийх
17. Талийх
18. Амьд явах хоног аргагүй гүйцэж
19. Дэлхийн тоос хөдөлгөж, их юм үзлээ
20. Насан өөд болох
21. Өвгөн шувуу буцах
22. Амьдрах өдөр тоотой гэдгийг илтгэх

ЗОХИОЛЫН ЗОХИОМЖ

Зохиолч зохиолын уран санааг хүүрнэл, байгалийн зураглал, зүүд, харилцан яриа, дотоод яриа, үглэл, зохиолчийн тэмдэглэл, эргэцүүлэмж, дурсамж, өчил, хөрөг зэрэг нэгжүүдээс сонгон хэрэглэхийг зохиомж гэнэ. Зохиомжийг тодорхой зорилготой хэрэглэдэг.

Дурсамж :

- Дайнд явсан
- Эхнэр авсан
- Хийж явсан ажил хөдөлмөр (ухуулагч)

} Жаран хэдэн жил дэлхийн тоос хөдөлгөж, их юм үзлээ. Гомдол алга. Ийм тийм дутуу юм алга. Олны дунд явлаа.

Дүгнэлт

Амьдралын жам ёсыг монгол ахуй, соёл, уламжлал, эх орны үнэ цэнтэй холбон, монгол хүний уужуу тайван ухаан, нөхөрлөл дунд үхлийг үзэх үзлийг дүрсэлснээрээ уг зохиол нь цэвэр монгол үндэстний дангааршлыг харуулсан гайхамшигт зохиол.